



ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН  
ХАМГААЛАЛЫН САЙД С.ЭРДЭНЭ  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.4.20 № 04/57 ЗАГ-ТАГ

Гэрээний хэрэгжилтийг хангуулж,  
дутуу ажлыг гүйцээж хийлгэх  
тухай.

ХАХНХС таны багцад хамаарагдах “Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д аудит хийх явцад Төрийн өмчийн XI байр, Хүүхдийн төлөө үндэсний газрын барилгын их засварын ажлыг 445,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр “Б-Софт” ХХК-ийн тендерт шалгарчээ.

Тус компани их засварын ажлыг 2012 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс мөн оны 12 дугаар сарын 10-ны өдөр ашиглалтад оруулахаар гэрээнд захиалагчийг төлөөлж ХТҮГ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч И.Нарантуяа, Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга Д.Бямбацогт, гүйцэтгэгчийг төлөөлж “Б-Софт” ХХК-ийн ерөнхий захирал Р.Элбэгбаян, ерөнхий инженер Б.Бадрах-Өлзий нар гарын үсэг зурж, ХАХНХЯ-ны ТНБ даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Отгонжаргал баталсан байна.

“Б-Софт” ХХК нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу тендерт оролцон шалгарч уг засварын ажлыг 445,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр гэрээ хийсэн боловч энэ дүнд багтааж хийлгүй, 55,0 сая төгрөгийн нэмэлт ажлын шууд гэрээг хийж, нийт барилга засварын ажлыг 500,0 сая төгрөгөөр хийхээр болжээ.

Нэмэлт ажлыг 55,0 сая төгрөгөөр гүйцэтгэх “Б-Софт” ХХК нь ХТҮГ-тай 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдөр байгуулж, өмнөх гэрээнд оролцсон дээрх нэр бүхий хүмүүс гарын үсэг зурж, баталсан нь Сангийн сайдын 290 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.26-т “Хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтын дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч ашиглахгүй.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

ХТҮГ-ын барилгын их засварын ажлыг 2013 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр 17 хүний гарын үсэг зурсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комиссын акт”-д “Байнгын ашиглалтад хүлээн авав” гэжээ.

Гэтэл барилгын гаднах пасадны ажил (3 талын гаднах шавардлага, будаг хийх), дээврийн болон борооны ус зайлуулагч хийх, гадна талын хаалга солих, шат, довжоог засч сайжруулах зэрэг нийт 65,7 сая төгрөгийн ажил хийгдээгүй байхад техникийн комиссын акт гарсан байна.

Иймд Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15.1-ийн 12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...” гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Хүүхдийн төлөө үндэсний газрын барилгын их засварын ажлыг тендер зарлаж 445,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр “Б-Софт” ХХК-тай гэрээ байгуулсан атал нэмэлт 55,0 сая төгрөгийн ажлыг хийлгэх гэрээг байгуулж, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалын заалтыг зөрчсөн учраас холбогдох ажилтнуудад хариуцлага тооцох

2. Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй 65,7 сая төгрөгийн ажлыг 2013 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор “Б-Софт” ХХК-иар хийлгэх дуусгах ажлыг зохион байгуулах

3. Хүүхдийн төлөө үндэсний газар газар нь “Б-Софт” ХХК нь их засварын ажил дууссаны дараа гэрээг дүгнэж, гэрээний тусгай нөхцөлд заасан заалтын дагуу хариуцлага тооцож ажиллах

4. ХТҮГ-ын барилгын их засварын дуусаагүй ажлыг хэрхэн гүйцэтгэсэн ажлын үр дүнг Үндэсний аудитын газарт 2013 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор албан ёсоор хариу мэдэгдэхийг ХАХНХЯ-ны ТНБД Б.Отгонжаргал, СХОХ-ийн дарга Мөнхзул, ХТҮГ-ын дарга И.Нарантуяа, “Б-Софт” ХХК-ийн ерөнхий захирал Р.Элбэгбаян нараас ШААРДАЖ байна

#### Албан шаардлага

Бичсэн  
Үндэсний аудитын газрын ГАГ-ын  
ахлах аудитор  
Г.Цэдэнбалжир  
Нийцлийн аудитын газрын  
аудитор  
Э.Уянга  
УХА0122

Танилцаж, зөвшөөрсөн  
Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалалын  
яамны ТНБДарга  
Б.Отгонжаргал  
Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн  
дарга  
Х. Мөнхзул  
Хүүдийн төлөө үндэсний газрын  
дарга  
И.Нарантуяа  
“Б-Софт” ХХК-ийн захирал  
Р.Элбэгбаян  
УЛААНБААТАР ХОТ